



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 1109

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх, даацыг тодорхойлох хээрийн судалгааны ажлыг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Гантуяа

(Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүн:

Л.Чанцалмаа

(1 дүгээр багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(2 дугаар багийн Засаг дарга)

Д.Амартүвшин

(Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Т.Өлзийбуд

(Газрын даамал)

2.Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх, хээрийн судалгаа хийх ажлын удирдамж, шаардагдах шатахууны зардлыг хавсралтаар баталсугай.


3.Бэлчээрийн даац тодорхойлох ажлыг удирдамжийн дагуу чанартай, хугацаанд нь зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (М.Гантуяа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ ДАРГА



Л.БАДАМХАНД

Сумын Засаг даргын 2024 оны
08 сарын 07 өдрийн 1108 тоот
захирамжийн хавсралт



**БЭЛЧЭЭРИЙН ГАЗРЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ФОТОМОНИТОРИНГИЙН
АРГААР ҮНЭЛЭХ ХЭЭРИЙН СУДАЛГАА ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ**

НЭГ. Зорилго

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх хээрийн судалгааг хийх тухайн бүс нутагт жил бүр давтамжтайгаар бэлчээрийн өөрчлөлтийг тодорхойлох фотомониторингийн цэг байгуулах, цэгийн мэдээллийн санг үүсгэх, бэлчээр ашиглалтын хэсэгт үнэлгээ өгч, зохих арга хэмжээг авч багийн иргэдийн нийтийн хурал болон сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлан мэдээг танилцуулж үнэлгээ дүгнэлт өгөхөд энэхүү ажлын гол зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Сумын 2 дугаар багийн бэлчээр ашиглалтын 3 хэсгийн 9 цэг

Гурав. Хугацаа

2023 оны 08 дугаар сарын 6-наас 08 сарын 10-ний өдрийн дотор

Дөрөв. Явах чиглэл

Сумын төв-Эрдэнэ толгой- Гозгор толгой- Сэвхүүлийн говь- Зүйтийн тал- Дэвсэг толгой- Бэхтийн ухаа- Хүрэн дух- Найман шороо-Хавхагт- сумын төв нийт 280км.

Хүрэх үр дүн:

- Бэлчээрийг зохистой ашиглах, бэлчээрийн нөөц, бэлчээрийг нөхөн сэргээх, бэлчээр зохион байгуулалтыг төлөвлөх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болно.
- Бэлчээрийн даацыг тогтоож үнэлгээ хийснээр хонин толгойгоор илэрхийлсэн бэлчээрийн чадавхийг бэлэн байгаа малын тоотой харьцуулан бэлчээрийн даац хэтэрсэн эсвэл дутуу ашиглаж байгаа болон нөхөн сэргээх шаардлагатай эсэхийг тодорхойлно.

➤ Бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлох ургацын дээж авах цэгийн тоог сумынхаа нутаг дэвсгэрт байгаа бэлчээрийн үндсэн төрөл, хэв шинжийг төлөөлж чадахүйц хэмжээнд нэмэгдүүлэх, бэлчээрийн ургацын мэдээллийг сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловруулахад ашиглах

Хавсаргах баримт, бүрдүүлэх багаж, унаа машин:

- Ажил гүйцэтгэхэд шаардагдах шатахууны зардлын тооцоо /хүснэгт №1/
- Багаж авч явах /хайя 2 ш, гялгар уут, 50 метрийн урттай метр, 1м2-ийн тор,
- Унаа машин олох
- GPS багаж
- Зургийн аппарат

Удирдамж боловсруулсан:

Газрын даамал: *Т.Өлзийбуд* Т.Өлзийбуд

Бэлчээрийн даац тодорхойлох ажилд шаардагдах шатахууны тооцоо

Д/Д	Шатахуун болон замын зардал					
1	Чиглэл	Туулах зам /км/	100 км-т зарцуулах шатахууны хэмжээ /л/	Нийт зарцуулах шатахууны хэмжээ /л/	Нэг литр шатахууны үнэ /төгрөг/	Нийт шатахууны үнэ /төгрөг/
2	Сумын төв- Эрдэнэ толгой- Гозгор толгой-Сэвхүүлийн говь- Зүйтийн тал- Дэвсэг толгой- Бэхтийн ухаа- Хүрэн дух- Хавхагт- Найман шороо- Сумын төв	280 км	10л	28л	2560төг	71 680 төг
Нийт дүн:						71 680 төг